



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 102/19

Мяндалговь

Малын гоц халдварт өвчнөөс  
урьдчилан сэргийлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 4.5.9, 4.5.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Малын гоц халдварт "А" зэрэглэлийн "Шүлхий" өвчин Сайнцагаан суманд гарсан тул уг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор 2017 оны 8 дугаар сарын 12-ний өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

Хоёр. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, үзлэг тандалтыг тухай бүр хийх, малын хөдөлгөөнд тавих хяналтыг чангатган ажиллах, хяналт, ариутгалын постуудын тоог нэмэх, хорио цээрийн дэглэмийг чангатгаж холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Аймгийн хэмжээнд аливаа найр наадам, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахыг, хорио цээрийн дэглэм тогтоосон бүсээс малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг аймгийн төв, Улаанбаатар хот, бусад аймаг хотуудад тээвэрлэх, худалдан борлуулахыг хорио цээрийн дэглэм бууртал хориглосугай.

Дөрөв. Захирамжийн биелэлтийг хангуулж, нэгдсэн удирдлагаар ханган, үр дүн, ажлын явцыг танилцуулж байхыг Онцгой комиссын орлогч дарга /Я.Алтанхундага/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200785